

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД


Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлд:

“ХҮИ.1. 2015 оны эхний хагас жилд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав:

1.1. Өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж байгаа зөрчлийг арилгуулан, цаашид хуульд заасан хугацаанд багтаан шийдвэрлэж байх талаар яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг өгч хяналт тавин ажиллах;

1.2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг яамныхаа Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраар хянуулж, тогтоосон хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байх.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР